



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2024 оны 04 сарын 02 өдөр

Дугаар А/259

Арвайхээр сум

Тендерийн гүйцэтгэгчийг сонгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйчилгээ худалдан авах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1, 48 дугаар зүйлийн 48.2.4, Захиргааны ерөнхий хуулийн 43, 46 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үнэлгээний хорооны хуралдааны 2024 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 07 дугаар дүгнэлтийн дагуу ЗТХЯ/20240101028/01/01 урилгын дугаартай А0302 авто замаас Хайрхандулаан сум хүртэлх хатуу хучилттай авто зам, 3.2 км (Өвөрхангай, Хайрхандулаан сум) ажлыг 2,672,672,483 (хоёр тэрбум зургаан зуун далан хоёр сая зургаан зуун далан хоёр мянга дөрвөн зуун наян гурав) төгрөгөөр Өвөрхангай АЗЗА ТӨХК-иар гүйцэтгүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Тендерт шалгарсан аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан, ажлын явцад хяналт тавьж, гэрээнд заасан хугацаанд хүлээн авахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Б.Мөнхбат)-т даалгасугай.

3. Шалгарсан аж ахуйн нэгж санхүүжилтээ авахад шаардагдах материалыг бүрдүүлэн өгөхийг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Худалдан авах ажиллагааны газар (Ц.Идэрсайхан)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



И.ДОРЖСҮРЭН

6224 11 0526

D:My Doc. Zahiramj. Zasag darga